

СУРАЛЦАГЧДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦААНЫ АСУУДАЛД

О.Сарантуяа

Социологийн ухааны доктор (Ph.D)

Монголын сургууль, боловсролын хүрээнд XX зууны 30-аад он хүртэл эрэгтэйчүүд үнэмлэхүй ноёрхож, ордны уламжлалт (XIII, XIV-XVIII), шашны (буддын) боловсролын тогтолцоо нь зөвхөн эрэгтэйчүүдэд үйлчилж байсан бөгөөд иргэний боловсролын тухайд эцэг эхчүүд эрэгтэй хүүхдээ өрхийн тэргүүн, айл гэрийн удам залгах хүн гэдэг утгаар нь эн тэргүүн анхаарч ирсэн байдаг. Харин бичиг үсэгт суралцах боломж тухайн үед гагцхүү сурвалжит язгууртан эмэгтэйчүүдэд л олддог байв. 1921 оны 8 дугаар сарын 14 -нд Ардын Засгийн Газраас сургууль байгуулах шийдвэр гаргаж, мөн оны 8 дугаар сарын 31-нд Дотоод Яамны дэргэд сургуулийн хэлтсийг байгуулж (Шагдар 2000: 334), хүүхдийг хүйсээр үл ялгаварлан сургаж эхэлснээр XX зууны дунд үе гэхэд бага сургуульд суралцагчдын хүйсийн харьцааг тэнцвэржүүлж, улмаар бүрэн дунд болон мэргэжил олгодог дунд, их дээд сургуулиудад эмэгтэйчүүдийн эзлэх хувь жилээс жилд тогтмол нэмэгдэж ирсэн юм.

Социалист тогтолцооны үед (1960-1990) дунд болон их дээд сургуулийн оюутан сурагчдын хүйсийн харьцаа үндсэндээ хүн амын нөхөн үржихүйн харьцаагаар тэнцвэржиж, сурч боловсрох, мэргэжил эзэмших, ажил эрхлэгчдийн хүйсийг төрийн бодлогоор зориуд төлөвлөгөөтэйгөөр зохицуулж байсан нь эерэг болон сөрөг үр дагаврыг бий болгосон юм.

Монгол Улсад “хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм” (МУҮХ. 1992) байгуулж эхэлснээр иргэд сурч боловсрох эрхээ жинхэнэ утгаар эдлэх болж, боловсролын салбарт шинэ орчин нөхцөл бүрдсэн. Боловсрол олгох төрийн өмчийн ноёрхол эцэс болж сургалтын үйл ажиллагааг хувийн хэвшил оролцсон өрсөлдөөн тодорхойлох болсон нь боловсролын шинэчлэлд чухал алхам болсон юм. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын хүрээнд хувийн өмчид тулгуурласан сургууль олноор байгуулагдаж 2004-2005 оны хичээлийн жилийн байдлаар 219 их, дээд сургууль, коллеж, /үүнээс төрийн 76, хувийн 137/ албан ёсоор үйл ажиллагаа явуулж байгаа (МУСЭ 2005: 319) нь иргэдийн сурч боловсрох хэрэгцээ нэмэгдсэнийг илтгэж байгаа хэдий ч, нөгөө талаас сургалтын төлбөрөөр дамжуулан сургуулийг ашиг олох хэрэгсэл болгон хувиргах, өсвөр залуу үеийнхний сурч боловсрох хэрэгцээг санхүүгийн асуудал (төлбөрийн чадвар) буюу эцэг эхийн орлого, амьжиргааны түвшин тодорхойлох болсон зэрэг сөрөг үр дагаврыг буй болголоо.

Хүснэгт.1 Суралцагчдын дунд эмэгтэйчүүдийн эзэлж буй хувь¹⁹ (1998-1999 оны байдлаар)

	Бүгд	Өмчийн хэлбэр	
		Улсын	Хувийн
Наймдугаар анги төгсөгчид	58.2	-	-
Аравдугаар анги төгсөгчид	62.0	-	-
Нэгдүгээр дамжаа	63.1	60.1	70.8
Хоёрдугаар дамжаа	63.1	61.0	69.7
Гуравдугаар дамжаа	64.2	63.0	68.1
Элсэгчид	61.5	59.4	68.1
Төгсөгчид	64.5	63.0	73.4
Мэргэжлийн анхан ба	55.6	55.3	72.0
Дээд боловсролын дипломтой	70.0	71.4	59.3
Баклавр	64.6	61.9	70.4
Мастер	64.2	64.1	77.8
Total	63.5	61.3	70.1

19Х.Гүндсамбуу. Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага. УБ., 2002, 552 дахь тал.

Ялангуяа сургуулиудын өрсөлдөөний явцад сургалтын чанар, төлбөрийн хооронд ялгарал бий болж, зарим эцэг эхчүүд хүүхдээ их, дээд сургуульд ёс юм шиг сургах *хандлага* бий болсны зэрэгцээ сурах сонирхолтой ч эдийн засгийн бэрхшээл, амжиргааны ядуурлаас болж суралцах бололцоогүй тодорхой бүлэг бий болсон гэж хэлж болно. Ийм нөхцөл байдалд бий болсон сөрөг үр дагаврын нэг нь хүйсийн зохистой харьцаа алдагдаж, суралцагчдын дунд эмэгтэйчүүд илт давамгайлах болсон явдал юм.

Түүнчлэн боловсрол дахь хүйсийн зөрүүтэй байдлаас улбаалан өрх толгойлсон ганц бие эмэгтэйчүүд, гэрлэлт ба гэр бүл салалт, феминизмын давамгайлал ба уламжлалт ёс заншлын хоорондох зөрчил, зэрэг олон асуудалд сөрөг үр дагавар илэрч байгаагийн зэрэгцээ эдийн засаг, улс төр, оюуны амьдралд тулгарч буй нийтлэг асуудлуудад ч энэ нь нөлөөлж байгаа юм. Тиймээс боловсролд хүйсийн зөрүүтэй байдал нэмэгдэх болсны шалтгаан нөхцлийг сайтар судалж, танин мэдэх шаардлага дэвшигдэж байна. Энэ асуудалд нийт хүн амын бүтэц дэх хүйсийн харьцаа, боловсролын салбарт баримтлах төрийн бодлого, үйл ажиллагаа гэсэн хоёр үндсэн шалтгаан юуны өмнө холбогдоно. Боловсрох үйл явц дээрх хоёр шалтгаанаас хамаарч буй эсэхийг тодруулах үүднээс нарийвчлан шинжилж үзэхийг зорьлоо.

1. Хүн амын насны бүтэц дэх хүйсийн харьцааны хувьд: Албан ёсны статистик баримтад суралцах насны бүх ангилалд хүйсийн харилцаа ойролцоо байна.

Хүснэгт.2 Хүн амын хүйсийн байдал²⁰ (Асаар)

	1999			2002		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд (мянган хүн)	2 373.5	1 178.0	1 195.5	2 475.4	12281	1 247.3
үүнээс:						
5-9 нас	285.7	144.2	141.5	265.7	132.2	133.5
10-14 нас	317.4	159.3	158.1	313.3	157.0	156.3
15-19 нас	263.3	133.3	130.0	289.7	147.4	142.3
20-24 нас	235.8	118.1	117.7	263.0	132.5	130.5
25-29 нас	216.7	108.0	108.7	228.6	113.6	115.0

Боловсролын салбарт хүйсийн харьцаа алдагдсан байдлыг нягтлан үзэхэд Монгол улсын нийт хүн ам, түүний дотор өсвөр, залуу насныхны хүйсийн харьцаанаас хамааралгүй байна гэсэн дүгнэлт аяндаа гарна.

2. Төрийн бодлогын хувьд: Монгол Улсын хууль тогтоомжид тус улсын иргэн сурч боловсрох эрхтэй бөгөөд суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй (МУҮХ. 1992: 16.7) гэсэн заалт болон төрөөс боловсролын салбарт баримтлан хэрэгжүүлсэн бодлого, боловсролын тогтолцооны шинэчлэл, боловсрол олгох үйл ажиллагааны үндсэн зарчмууд нь хүйсийн тэгш бус байдлыг бий болгох, тэтгэхэд чиглээгүй явж ирснийг гэрчилнэ. Өөрөөр хэлбэл, боловсролын салбар дахь хүйсийн харьцааны зөрүүтэй байдалд төрийн бодлого, үйл ажиллагааны зарчим, шууд нөлөөлөх үндэс байхгүй гэдэг нь ойлгогдоно. Иймд боловсрол дахь хүйсийн харьцааны зөрүүтэй байдлын эх үүсвэрийг өнөөгийн монголын нийгмийн өмнө тулгарч буй олон шийдвэрлэх асуудлыг үндэслэж буй эдийн засаг улс төр, оюуны тогтолцооны шинжтэй холбон үзэх нь зүйтэй.

Судалгааны статистик болон бусад дүнгээс үзвэл, суралцагчдын дунд хүйсийн тэгш бус байдал бий болсон нь тоталитари хэв маягийн дэглэмээс ардчилсан дэглэмд шилжиж буй өнөөгийн цаг үетэй давхцаж байгаа юм. Шилжилтийн үеийн эдийн засгийн хямрал нь нийгмийн дийлэнх гишүүдийн амьжиргааны түвшинг ихээхэн доошлуулсан билээ. Төрөөс иргэдийн өмчлөх эрхийг жинхэнэ ёсоор сэргээж, тэдэнд социалист өмчөөс аль болох тэгш хүртээж, хуваарилах арга хэмжээг авч явуулсан боловч 2003-2004 оны байдлаар гэхэд хүн амын 36,1%, үүнээс хотод 30,6%, хөдөөд

202000 оны Хүн ам, орон сууцны тооллого. МУҮСГ. УБ., 2001 он. 41 дэх тал

43,4% (МУСЭ 2005: 209) нь амьжиргааны баталгаажих түвшнээс доош орлоготой буюу ядуу болон нэн ядуу амьдарч байна. Ядуурлыг тэтгэгч нэг шалтгаан буюу хүчин зүйл бол социализмын үеийн иргэд хувийн өмчтэй харьцаж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх ямар ч туршлагагүй байсанд орших бөгөөд зүгээр шахам хувьчилсан нийгмийн өмч олон хүний хувьд ирээдүйгээ хуурамчаар баримжаалахад хүргэсэн юм. Энэ нь:

1. 90-ээд оны эхэн үед “Зах зээлийн нийгэмд өмч хөрөнгөтэй буюу мөнгөтэй хүн аз жаргалтай, хангалуун сайхан аж төрж болно” (Уртнасан 2001: 49) гэсэн шинэ үнэлэмж, төсөөллөөр илэрч байв. Энэ байдал хөдөөд иргэдийн малжих хандлагаар илэрч, бэлчээрийн мал аж ахуйг орлогын ганц эх сурвалж болгосон айл өрхийн тоо эрс өссөн нь (2001 онд 185 546, 2002 онд 175 911, 2003 онд 172 410, 2004 онд 169 024 - Монгол Улс зах зээлд 2004: 162) ажиллах хүчинг шаардаж, энэ салбарт эцэг эх, ах дүүгийнхээ хамжлага болон ажиллах хүүхдийн тоог ч мөн адил нэмэгдүүлсэн. Үүгээр нөхцөлдөн сургуулийн насныхны дунд сургуулиа орхих, завсардах явдал түгээмэл болж, суралцагчдын хүйсийн тэнцвэр алдагдахад бодитойгоор нөлөөлсөн байна;

2. Ёийгмийн сэтгэлзүйд 90-ээд оны дунд үеэс "Мөнгө амьдралын баталгаа мөн ч мөнгө олох хэрэгсэл нь худалдаа арилжаа бус, харин боловсрол, мэргэжил" (Уртнасан 2001: 82) гэдэг төсөөлөл давамгайлж иржээ. Энэ нь, нэг талаар өндөр боловсрол мэдлэгтэй, эсвэл нийгэмд эрэлт хэрэгцээтэй мэргэжил эзэмшсэн хүн амжилтад хүрч байгааг анзаарч мэдэрсэн хэрэг боловч, нөгөө талаар, ямар нэг шатны боловсрол, мэргэжлийн дипломтой болсон л бол ажлын байр, цалин нь баталгаатай байдаг байсан социализмын үеийн сэтгэлгээний илрэл болно. Бодит байдалд боловсрол мэргэжилтэй нь бус, харин чадвартай, зүтгэлтэй, хөдөлмөрч нь нийгэмд эзлэх байр сууриа түрүүлж тодорхойлох боломж нээгдсэнийг хүмүүс төдий л олж хараагүй байв. Иймээс өнөөдөр монголын нийгэмд дээд боловсролын дипломтой ажилгүйчүүдийн бүлэг бодитойгоор буй болсон бөгөөд тэдний дийлэнх нь эмэгтэйчүүд байгаа юм;

3. 90-ээд оны эцэс, 2000-аад оны эхэн гэхэд монголын нийгмийг зах зээлийн нийгмийн шинж төрх үндсэндээ тодорхойлох болов. Гэсэн ч нийгмийн сэтгэлзүйд социализмын үеийн идэвхгүй хойрго, бэлэнчлэх сэтгэлгээ, шилжилтийн үеийн пессимист, тодорхойгүй мухардмал үзэл төсөөлөл хадгалагдсаар байгаа нь суралцагчдын хүйсийн тэнцвэрт бус байдалд дам нөлөөлж байна. Энэ нь, ялангуяа суралцагчдын мэргэжил сонгож байгаа байдлаар нэн тодорхой илэрч байна. Үүнийг 2003-2005 онд явуулсан “Боловсролын тогтолцоон дахь хүйсийн асуудал”* судалгаанд оролцогчдын хариултын байдлаас харж болох юм. Судалгаанд оролцогчдын 11,9% нь санхүү, эдийн засаг, 5,2 % нь хуульч, 8,7% нь эмч, 7,1% нь багш мэргэжил сонгох сонирхолтой байгааг анхаарч, ер нь боловсрол мэргэжлийн сонголтын байдлыг нийгмийн эрэлт хэрэгцээ, хүйсийн хамааралтай холбон нарийвчлан судлах шаардлагатай;

4. Ядуурлын улмаас газар авсан авилгал, гэмт хэрэг, архидалт, ёс суртахууны доройтол зэрэг нь нийгмийн олон нийтийн ирээдүйд итгэх итгэлийг алдагдуулж, тодорхойгүй болгосон. Үүний илрэл нь эцэг эхчүүдийн үр хүүхдийнхээ ирээдүйд санаа зовж түгшсэн “айдас” юм. Судалгааны дүнгээс үзвэл, чухам энэхүү айдас суралцагчдын хүйсийн харьцааг өөрчлөх тодорхойлогч хүчин зүйл болсон байж болзошгүй байна. Тухайлбал, "Ямар нэг шалтгааны улмаас эрэгтэй эсвэл эмэгтэй хүүхдийнхээ аль нэгийг сонгон суралцуулах шаардлага гарвал Та ямар сонголт хийх вэ?" гэсэн асуултад судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн 58,2 хувь нь "охиндоо боломж олгоно" гэж хариулжээ. Яагаад ингэж хариулсныг нь тодруулахад "эрэгтэй хүүхэд боловсрол эзэмшээгүй ч нийгэмд байр сууриа олоод, амьдралаа аваад явчихна; харин эмэгтэй хүн боловсрол, мэргэжилтэй бол “төрөлх” сул дорой байдлаа даван туулж, бусдын дор орохгүй аж төрж чадна” гэсэн байр сууринаас хандаж байв. Энэчлэн, эмэгтэйчүүд илүү суралцаж байгаа шалтгааныг судалгаанд оролцсон эцэг эхчүүд: 1. Эмэгтэй хүүхэд айл гэрийн эзэгтэй, хүүхдийн эх болдог учир бусдад гологдохгүй байх (ирээдүйн гэр бүлд эм хүйс эрх тэгш байх); 2. Өөрөө өөрийгөө авч явах, тэжээх чадвартай болох; 3. Боловсролгүй эмэгтэй, эрэгтэй хүний адилаар хүнд хүчир ажил хийх бололцоогүй; 4. Хүүхэд төрүүлж, өсгөх зэргээр цаг хугацаа алддаг гэх зэргээр тодруулсан байна. Харин судалгаанд оролцсон багш, нийгмийн ажилтнууд: 1. Хүмүүс эмэгтэй хүүхдээ хүнд амьдрал туулах вий гэж эмээдгийн улмаас боловсрол эзэмшүүлэхийг зорьдог болсон; 2. Өрхийн амжиргааны түвшин буурахын хэрээр

мөнгөний төлөө эрэгтэй хүүхдээ сургуулиас завсардуулж, ажил хөдөлмөрт зүтгүүлэх болсон; 3. Малчин эцэг эх эн тэргүүн эрэгтэй хүүхдээ хөдөлмөрийн хамжлага болгож, мал маллуулах болсон; 4. Сургуулийн орчинд хөвгүүдийг сахилга батгүй, хэцүү, хэнэггүй гэдэг нэрээр бага анхаарч, охидыг илүү дэмждэг нь хөвгүүд сурлага, хүмүүжлээр доголдож улмаар сургуулиа орхиход хүргэдэг гэсэн хэд хэдэн шалтгааныг онцолж байгаа юм. Сонирхолтой нь, судалгаанд оролцсон эцэг эхчүүд гэр бүлийн хүүхдийн тоог 2-4 харин хүйсийн харьцаа нь 1:1 юмуу аль эсвэл 2:2 байвал зохистой гэжээ. Гэхдээ сонголтыг тодорүүлж эрэгтэй эмэгтэй хүйсийн хүүхэд тухайн гэр бүлд хэр чухал байгааг лавлахад 26.6 хувь нь хүү, 19.5 хувь нь охин нь илүү байвал сайн гэж үзсэн байна. Зөвхөн эдгээр мэдээллээс л гэхэд эцэг эхчүүд эмэгтэй хүүхдээ сургах, боловсруулах талд илүүтэй санаа тавьдаг ч гэр бүлийн гишүүний хувьд эрэгтэй хүүхдийг илүү сонгох хандлага давамгайлж байгаа нь илэрхий байна. Энэ нь эрэгтэй хүүхэд айл гэрийн удам залгах хүн гэж үздэг уламжлалт ойлголт зохих хэмжээнд хадгалагдаж байгаагийн илрэл боловч монголын өнөөгийн нийгэмд боловсролын хүйсийн асуудалд субъектив хүчин зүйлийн нөлөө их, олон талтайг харуулж байгаа юм.

Боловсролыг үнэ төлбөргүй олгодог тогтолцоо эвдэгдэж, бүх нийтийн ерөнхий боловсролыг л төлбөргүй (МУБХ. 2002) олгох болсон нь амьжиргааны дунд болон доогуур түвшинтэй өрх (монголын нийт өрхийн 91%), түүний дотор олон хүүхэдтэй гэр бүлийн өрхийн төсөвт шууд нөлөөлж, улмаар нэг гэр бүлээс суралцагчдын тоо, хүйсийн харьцааг тодорхойлдог хандлага бий болжээ. Төрөөс болон гадаад, дотоодын төрийн бус байгууллага, буяны (шашны) байгууллагын шугамаар энэ сөрөг хандлагыг арилгах арга хэмжээг авч байгаа хэдий ч үр дагавар нь нэгэнт буй болж нийгэмд бодитойгоор үйлчилж эхэлснийг нарийвчлан судлах шаардлагатай байна. Суралцагчдын дунд бий болсон хүйсийн ялгаатай байдал нь цаашдаа нэлээд хугацаанд хадгалагдах төлөвтэй байгаа учир тухайлбал, төрөөс суралцагчдын мэргэжил, боловсролын сонголт, боловсрол эзэмших байдлыг нийгмийн эрэлт хэрэгцээтэй уялдуулах механизм бүрдүүлэх, хүйсний асуудлыг зөв уялдуулах зэргийг анхаарваас зохилтой байна.

Ашигласан материал

1. БТХА. 2003-2005. Боловсролын тогтолцоон дахь хүйсийн асуудал. Социологийн судалгаа: ФСЭХ 2003-2005.
2. Гүндсамбуу, Х. 2002. Монголын нийгмийн давхраажил: хөгжил, хандлага (XX зуун). Улаанбаатар: УА.
3. МУБХ. 2002. Монгол Улсын Боловсролын Хууль. Төрийн мэдээлэл. 2002 №19.
4. МУҮХ. 1992. Монгол Улсын Үндсэн Хууль. Улаанбаатар.
5. Монгол Улс зах зээлд 2004. “Монгол улс зах зээлд” статистикийн эмхтгэл 1989-2002. Улаанбаатар: МУҮСГ.
6. МУСЭ. 2005. Монгол Улсын Статистикийн Эмхтгэл. Улаанбаатар: МУҮСГ.
7. Сарантуяа, О. 2005. Шилжилтийн үеийн боловсролын нийгмийн асуудал. Улаанбаатар: ШУА-ийн ФСЭХ.
8. Уртнасан, Ц (ред). 2001. Нийгмийн шинэчлэл: амьдралын хэв маягийн өөрчлөлт. Улаанбаатар: ШУА-ийн ФСЭХ.
9. ХАОСТ. 2001. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого. Улаанбаатар: МУҮСГ.
10. Шагдар, Ш. 2000. Монгол улсын боловсролын товчоон. Улаанбаатар.
11. Francis, B., Ch. Skelton 2001. Investigating gender: contemporary perspectives in education. Philadelphia: Open University Press.
12. Leach, F. (Ed) 2003. Practicing Gender Analysis in Education. Herndon: Oxfam.